

АШИГТ ДОЛООЦ

Ашигт тус: Энэхүү долооц нь малын бие махбодид шаардлагатай эрдсийг нөхөж, бодисын солилцоог идэвхжүүлж, дархлааны тогтолцоог нь сайжруулж, ашигт шимийг нэмэгдүүлдэг.

Хэрэглэх заалт: Өвөл, хаврын улиралд үхэр, адуу, хонь, ямаа, тэмээг турахаас сэргийлэх, тураатай болон тамирдсан малыг тэнхрүүлэх зорилгоор зун, намрын улиралд малын тарга хүүч, ашигт шимийг нэмэгдүүлэх, фермийн аж ахуйд мах, сүүний гарцыг тогтмол нэмэгдүүлэхийн тулд долоолгож хэрэглүүлдэг. Мал, амьтны бие махбодийн дотоод орчныг тэнцвэржүүлэн, дархлааны тогтолцоог сайжруулан ашигт шимийг дээд зэргээр нэмэгдүүлдэг.



ТӨВ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮҮЛ
МЭНДИЙН АЛБА



МАЛЫН БИЕИЙН ДАРХЛАА
САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨГТӨӨ



Төв аймгийн Мал эмнэлгийн
газар

УТАС:70272361

Цахим хаяг : <http://vet.to.gov.mn/>

Facebook page:Төв аймгийн мал
эмнэлгийн газар /TUV.mn/

МАЛЫН БИЕИЙН ЕРӨНХИЙ ДАРХЛАА САЙЖРУУЛАХ ЗАРИМ ЗӨВЛӨГӨӨ:


Эдгэв халдвар, нян, бактери, мөөгөнцрөөс хамгаалах малын биеийн төрөлх чадварыг **"ДАРХЛАА"** гэж нэрлэдэг.

Дархлааг сайжруулахын тулд малын тэжээлд, тэжээллэг арчилгаа, маллагаа, цаг агаар гэх мэт олон хүчин зүйл нөлөөлнө.

Малын биеийн ерөнхий дархлааг сайжруулах, урьдчилан сэргийлэхдээ дараах зүйлд анхаарна.

Үүнд:

- ◆ Тарга хүч сайн авахуулах, авсан тарга хүчийг аль болох алдахгүй хамгаалах.
- ◆ Хужир, давс, төрөл бүрийн эрдэс, витамин нэмэгдлээр жилийн турш олгож байх.
- ◆ Дархлаа дэмжих бүтээгдэхүүн нэмэлтээр олгох. Үүнд:



ЗАГАСАН ТОС:

Загасан тосны ашиг тус:

- Урэвслийг бууруулах
- Биеийн эсэргүүцлийг сайжруулах
- Дархлааг сайжруулах
- Ус уналтыг багасгах
- Арьсны хуурайшилт болон загатналтыг багасгах
- Тэжээлд нэмэлтээр өгөх нь тэжээл идэх дуршлыг нэмэгдүүлнэ.

Хэрэглэх заалт:

Адуун : 40-200 мл
Үхэр : 30-180 мл
Хонь: 5-15 мл
Ямаа: 5-15 мл

Өдөрт нэг удаа амаар эсвэл тэжээлтэй хольж олгоно.



ХУУРАЙ ГЛЮКОЗ:

Ашиг тус: Биемахбодлын ус, сахар нөхөх, хорыг гадагшлуулах, ядарч доройтсон малд тамир тэнхээ оруулах зориулалттай.

Хэрэглэх заалт: Урьдчилан сэргийлэх зорилгоор болон ядарч доройтсон малд 100-200 гр тэжээлтэй хольж олгоно.

